

УУЛ УУРХАЙ ДАХЬ ЭМЭГТЭЙЧҮҮД БАЙГУУЛЛАГЫН  
МОНГОЛ ДАХЬ САЛБАР



**“МОНГОЛЫН УУЛ УУРХАЙН САЛБАР  
ДАХЬ ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН ОРОЛЦОО”  
СУДАЛГААНЫ УРЬДЧИЛСАН ДҮНГИЙН  
ТАНИЛЦУУЛГА**

2016 оны 3-р сар

**УУЛ УУРХАЙ ДАХЬ ЭМЭГТЭЙЧҮҮД (WIMM) ТББ**

Олон улсын уул уурхай дахь эмэгтэйчүүдийн сүлжээний Монгол дахь салбар болох “Уул уурхай дахь эмэгтэйчүүд” төрийн бус байгууллага ([www.wimmongolia.org](http://www.wimmongolia.org)) нь манай орны ашигт малтмал, олборлох салбарт ажиллаж буй эмэгтэйчүүдийн хувь нэмрийг таниулан зохих түвшинд үнэлүүлэх, ажлын үнэлэмжийг нь дээшлүүлэх, шийдвэр гаргах түвшинд хүрэхийг нь дэмжих, мөн бусад орны ажил нэгт эмэгтэйчүүдтэй холбох чиглэлээр 2014 оноос хойш ажиллаж байна. Тус салбар дахь тэнцвэртэй оролцоо, байгаль орчин, нийгмийн хариуцлагын асуудлыг бид түлхүүр үнэт зүйлээ болгон ажилладаг.

**СУДАЛГААНЫ ТУХАЙ ТОВЧ**

Манай байгууллагаас санаачлан тус олборлох салбар дахь эмэгтэйчүүдийн оролцооны өнөөгийн түвшинг тодорхойлох судалгааг өөрийн хүч хөрөнгөөр хийж байна. Монголд энэ чиглэлийн судалгаа ховор байгааг жишээ нь Дэлхийн банк цохон тэмдэглэж, энэ нь нийгмийн болон уул уурхайн бодлогод зөв тусгалаа олохгүй байх магадлалтай гэсэн байдаг<sup>1</sup>. Манай энэхүү судалгааны ажил нь Монголд нэн шинэлэг бөгөөд асуудлыг хөндсөн томоохон цараатай судалгаа болсон гэдэгт итгэж байна. Судалгаанд уул уурхайн салбартай холбоотой чиглэл бүрийн байгууллагууд оролцсоноос гадна боловсролын байгууллагыг ч бас хамарсан нь энэхүү судалгааг олон талаас нь иж бүрэн тодорхойлоход тус дөхөмтэй ажил болсон. Нийт 16,000 гаруй оролцогчыг хамарсан уг судалгааны ажлыг 8 сарын хугацаанд гүйцэтгэж урьдчилсан үр дүнг дор толилуулж байна.

<sup>1</sup> <http://www.wimmongolia.org/resources-in-mongolian/1>  
<http://www.wimmongolia.org/resources-in-english/mongolia-gender-disparities-in-labor-markets-and-policy-suggestions>

## МЭДЭЭЛЭЛ ЦУГЛУУЛСАН СУВАГ, АРГА

Уг судалгааг боловсруулж бэлтгэхэд дараахь суваг, мэдээллийн эх сурвалж, аргачлалыг ашиглав:

- Уул уурхайн компаниудаас асуулгаар мэдээлэл цуглуулах, үүнд:
  - Асуулгыг онлайнаар<sup>2</sup>, мөн имэйлээр авсан, мөн хэвлэмэл байдлаар зарим компаниудаас хариулт цуглуулсан.
  - Онлайн асуулгыг Ашигт малтмалын газрын вэбсайт дээр байрлуулсан.
  - Монголын үндэсний худалдаа, аж үйлдвэрийн танхим (www.mongol-chamber.mn), Уул уурхайн үндэсний ассоциаци (www.miningmongolia.mn)-ар дамжуулан гишүүдээс нь асуулгын хариулт авсан, мөн асуулга тарааж хариулт авахад Америкийн худалдааны танхим (www.amcham.mn), Монголын алт үйлдвэрлэгчдийн холбоо (www.mongoliagold.org), Монголын эрдэмтэн эмэгтэйчүүдийн холбоо (www.wstem.mn), Эмэгтэй геологчдийн клуб зэрэг байгууллагуудтай хамтран ажиллав.
  - Эрдэнэт, Оюу толгой, Эрдэнэс таван толгой, Эрдэнэс МГЛ, Бор-Өндөр, Алтайн хүдэр, МАК, Энержи Ресурс, МоЭнКо зэрэг монголын томоохон уул уурхайн компаниудаас тоон мэдээллийг зориуд авч, хүний нөөцийн холбогдох ажилтнуудтай нь санал солилцсон.
- Монголын үндэсний статистикийн газрын жил бүрийн сатистикийн холбогдох тоон мэдээллийг судалж, шинжлэв.
- МУИС-ын Геологи, геофизикийн танхим, ШУТИС, Монголын Үндэсний их сургуулийн Уул уурхайн инженерийн сургуулийн эрхлэгч, геологийн ангийн багш нартай санал солилцож, зөвөлгөө авсан.
- Гадаад орон, олон улсын байгууллагаас бэлтгэн гаргасан ижил төстэй тайлан, эмхэтгэлийг олж судалсан. Эдгээрийн жагсаалтыг дор хавсаргасан болно.

Уул уурхайн хэвгэн нийлүүлэлт	5	40	0	50	0
Эрэл, хайгуул	35	6 хөдөө явах, :	3	3	2
Уул уурхайн хэвгэн нийлүүлэлт	14	60	0	50	20
Эрэл, хайгуул	10	10	0	10	0
Элборлолт	27	18	0	0.07	0.11
Үйлдвэрлэл	1090	36	0	12	52
Эрэл, хайгуул	22	45	0	50	20
Үйлдвэрлэл	1033	7	45	1	0.1
Элборлолт	6498	32.5			4.3
Уул уурхайн элборлолт	<b>total 16005</b>	<b>27.40625</b>	<b>17.0354166</b>		0
Элборлолт				10.9	1.4
Уул уурхайн төмөг элборлолтын худ	389	23	40	70	0
Уул уурхайн сургууль	55	54	50	60	40
Үйлдвэрлэл	6498	32.5	5.8	42.2	42.2
<b>total</b>	<b>16005</b>	<b>27.40625</b>	<b>17.0354166</b>		<b>8.793958333</b>

Үндэсний статистикийн газар 2014 оны эцсийн улирлын байдлаар манай орны уул уурхайн салбарт нийт ажиллагсадын тоо 37 мянган хүн байна гэжээ. Харин манай энэхүү судалгаанд оролцож хариу өгсөн компаниудад ажиллагсадын тоог нийлүүлэн тоолж үзвэл 16000 хүн болж байгаа учраас уг судалгаа нь уул уурхайн салбарт нийт ажиллагсадын 35 хувь хамруулсан гэж хэлж болно. Иймд манай судалгааны үнэн зөв, бодит байдалд нийцсэн нь нилээдгүй баттай гэж дүгнэж байна.

<sup>2</sup> Асуулгын хуудсыг эндээс харна уу: [https://docs.google.com/a/temugelaw.com/forms/d/1S7YMTolva4VJmPd-YFW2ly1-wOmluWFgf92\\_qXK-w/viewform?c=0&w=1](https://docs.google.com/a/temugelaw.com/forms/d/1S7YMTolva4VJmPd-YFW2ly1-wOmluWFgf92_qXK-w/viewform?c=0&w=1)

## СУДАЛГААНЫ ҮР ДҮН

### I. Асуулганд хамрагдсан компани, байгууллагын талаар


Компаниудын ажиллагсадын тоо хамгийн бага нь 2 хүнтэй, хамгийн олон нь 6498 ажиллагсадтай гэжээ. Уул уурхайн нарийн мэргэжлийн судалгаа, үйлчилгээ үзүүлдэг, мөн ханган нийлүүлэлтийн компаниуд ерөнхийдөө цөөн 2-14 ажиллагсадтай, харин үйлдвэрлэл, олборлолтын түвшинд ажиллаж буй аж ахуйн нэгжүүд 380-2272 ажиллагсадтай байна.

Уул уурхайн салбарын компаниудын ажиллагсадын дундаж тоо 116 (хамгийн жин нэмсэн олон ажиллагсандтай 3 компанийг хасаад гаргасан тоо). Асуулганд оролцсон компаниудын үйл ажиллагааны чиглэлийг гаргахад дараахь дүр зураг гарч байна.




### II. Уул уурхайн салбарт ажиллаж буй эмэгтэйчүүдийн талаар

Сүүлийн 2 жилд буюу 2013-2014 онуудад дэлхийн зах зээл дээрхи ашигт малтмалын бүтэгдэхүүний үнэ унасантай холбоотойгоор Монголын эрдэс баялгийн салбар бүхэлдээ зогсонги байдалд орж, ажиллагсадын тоо тодорхой хэмжээгээр буурсан, харин нийт ажиллагсадын дотор эмэгтэйчүүдийн хувь 11 хувь болж, 2 дахин буурсан байгаа нь дээрхи Үндэсний статистикийн газрын тоон мэдээллээс харагдаж байна.



### Уул уурхайн компаниудын ажиллагсадын эмэгтэйчүүдийн хувь



Харин манай энэхүү судалгаанд оролцсон компаниудын хариултуудаас харахад 2015 оны 3-р улирлын байдлаар эрдэс баялгийн салбарын нийт ажиллагсадын дотор эмэгтэйчүүдийн хувь 27,4 байна. Энэ нь ҮСГ-ын тоон үзүүлэлтээс даруй 2 дахин их юм. Компаниуд сайн дураараа асуулгын хариуг өгсөн бөгөөд компаниудын нэрийг оруулаахгүй учраас оролцогчид үнэн зөв мэдээлэл өгөх бүрэн боломжтой, эрсдэлгүй байсан тул бид өөрсдийн энэхүү судалгааны 27,4 гэсэн хувийг үндэслэлтэй, бодит байдалд илүүтэй нийцэж байгаа гэж үзэж байна.

Манай судалгаанд хариу өгсөн компаниудын 6 хувь нь огт эмэгтэй ажилтан байхгүй, 2 хувь нь нийт ажиллагсадын 5 хүртэл хувь эмэгтэй гэсэн хариу өгсөн байна. Эдгээр аж ахуйн нэгжүүд нь ерөнхийдөө цөөн ажиллагсадтай, голцуу нарийн мэргэжлийн судалгаа, үйлчилгээ үзүүлдэг компаниуд аж. Огт эмэгтэй ажилтангүй, эсвэл маш цөөхөн байдгийн шалтгааныг ийнхүү тайлбарласан байна:




Дэлхийн эдийн засгийн форум (World Economic Forum) байгууллагаас хийсэн “2014 оны дэлхийн гендерийн ялгааны тайлан” зэрэг хэд хэдэн томоохон тайлан судалгаагаас харахад уул уурхайн компаниудад хамгийн олон удирдах түвшний эмэгтэйчүүдтэй орон бол Өмнөд Африкийн БНУлс (23%) байгаа бол энэхүү үзүүлэлт дэлхийн дунджаар 12 хувь байна. Харин Монголын уул уурхайн салбарын аж ахуйн нэгжүүдэд удирдах түвшинд ажиллаж буй хүмүүсийн 17 хувь нь эмэгтэйчүүд байна гэж манай судалгаагаар тогтоогдов. Бусад орнуудын энэхүү үзүүлэлт, мөн дэлхийн дундажаас дээгүүр байгаа нь чамлахааргүй сайн үзүүлэлт юм. Нөгөөтэйгүүр, дурьдсан гадаад орны болон олон улсын байгууллагын тайлангуудад “удирдах түвшин” гэдэгт гүйцэтгэх захирал, төслийн удирдагч зэрэг шийдвэр гаргах хэд хэдэн түвшний ажлын байр, мөн төлөөлөн удирдах зөвлөлд буй эмэгтэй төлөөллийг тоолсон бол манай судалгаанд “удирдах түвшин” гэдэгт “гүйцэтгэх захирал, дэд захирал, албаны дарга, хэлтэс газрын дарга, төслийн удирдагч, кэмпиин дарга, бусад шийдвэр гаргах түвшний” хүнийг тоолж, харин компаниудын ТУЗ-д томилогдсон эмэгтэйчүүдийг тоолоогүй. Хэрвээ тоолсон бол 17-с илүү хувь байх магадлалтай.

<sup>2</sup> Эдгээр тайлангийн дэлгэрэнгүйг доор буй судалсан материалын жагсаалтаас харна уу.

<sup>3</sup> Жишээ нь энэ тайланд Mining for talent. A study of women on boards in the mining industry, WIM (UK) and PwC, 2014, [http://www.pwc.com/ua/en/industry/metal\\_mining/mining/publications/women-in-mining.jhtml](http://www.pwc.com/ua/en/industry/metal_mining/mining/publications/women-in-mining.jhtml)

Уул уурхайн компаниудын  
удирдах түвшний эмэгтэйчүүдийн хувь




### III. Цалингийн зөрүү

Компаниудын ажиллагсадын тоо хамгийн бага нь 2 хүнтэй, хамгийн олон нь 6498 ажиллагсадтай гэжээ. Уул уурхайн нарийн мэргэжлийн судалгаа, үйлчилгээ үзүүлдэг, мөн ханган нийлүүлэлтийн компаниуд ерөнхийдөө цөөн 2-14 ажиллагсадтай, харин үйлдвэрлэл, олборлолтын түвшинд ажиллаж буй аж ахуйн нэгжүүд 380-2272 ажиллагсадтай байна.

Уул уурхайн салбарын компаниудын ажиллагсадын дундаж тоо 116 (хамгийн жин нэмсэн олон ажиллагсандтай 3 компанийг хасаад гаргасан тоо). Асуулганд оролцсон комп-аниудын үйл ажиллагааны чиглэлийг гаргахад дараахь дүр зураг гарч байна.

Ер нь эрэгтэй, эмэгтэй ажилтны цалингийн зөрүү олон зуун жилийн түүхтэй үзэгдэл юм. Тухайн орны нийт ажиллах хүчин дэх эмэгтэйчүүдийн жин нэмэгдэх тусам цалин хөлсний ялгаа багассаар ирсэн бөгөөд даяршсан өнөө үед энэхүү ялгаа хамгийн бага байгаа гэж Олон улсын хөдөлмөрийн байгууллагаас тодорхойлж байна. Гэсэн хэдий ч өндөр хөгжилтэй орнуудад ч, хуучин социалист орнуудад ч цалингийн зөрүү байдаг хэвээр. Жишээ нь, Их Британид 2014 оны сүүлчээр эрэгтэй, эмэгтэй хүний цалингийн харьцаа 1 фунт : 91 пенс байна гэж тус улсын Үндэсний статистикийн газраас тоолжээ, ингэхдээ энэхүү ялгаа нь түүхэндээ байгаагүй хамгийн бага ялгаа аж. Европын орнуудаас эрэгтэй, эмэгтэй ажилтны цалингийн зөрүү хамгийн бага орон нь Словени (3%), хамгийн их ялгаатай нь Эстони (29%) улс юм. Харин ихэнхи орнуудын уул уурхайн салбарын цалин хөлс харьцангуй өндөр байдагтай холбоотойгоор цалин хөлсний зөрүү ч арай их. Жишээлбэл, АНУ-д хүнд даацын тээвэрлэлт, тоног төхөөрөмжийн дамжлага зэрэг ажлын байранд эрэгтэй, эмэгтэй хүний цалингийн харьцаа 1 доллар : 82,3 цент (2014 оны байдлаар), Беларус т эрдэс баялгийн салбарын эмэгтэйчүүдийн цалин хөлс эрэгтэйчүүдийнхээс дунджаар 26,3 хувь бага (2011 оны байдлаар), Австралид цалингийн зөрүү ажлын байрны түвшнээс хамааран 13-27 хувь (2014 оны байдлаар) бөгөөд энэ зөрүү сүүлийн жилүүдэд аажмаар нэмэгдэх хандлагатай гэжээ.



Эх сурвалж: Үндэсний статистикийн газар, [www.1212.mn](http://www.1212.mn)

Харин Монголын уул уурхайн салбарт ажиллаж буй эмэгтэй, эрэгтэйчүүдийн цалин хөлсний зөрүүг тогтоохын тулд бид ҮСГ-аас өгч буй 2000-2012 онуудын тоон мэдээллийг харьцуулж тоолж үзэв. Ингэхэд 18,8 хувийн зөрүү тогтоогдож байна, өөрөөр хэлбэл эрэгтэй ажилтны авсан 1000 төгрөгт эмэгтэй ажилтны 812 төгрөг ногдож байна гэсэн үг.

Түүнчлэн манай асуулгын “Ижил туршлага, ажилласан жил, боловсролтой эмэгтэй, эрэгтэй ажилтнуудын цалингийн ялгаа зөрүү байгаа юу” гэсэн асуултад оролцогч компаниуд ийнхүү хариулсан байна:



#### IV. Уул уурхайн чиглэлийн мэргэжил олгож буй талаар

Манай орны эрдэс баялгийн салбарын мэргэжлийн боловсон хүчнийг ШУТИС-ын геологи, уул уурхайн сургууль 10 гаруй, МУИС-ын Геологи, геодезийн тэнхим 5, МҮИС-ын Уул уурхайн инженерийн сургууль 3, “Газарчин” дээд сургуулийн Уул уурхайн инженер технологийн тэнхим 7 мэргэжлээр тус тус бэлтгэж байна.

Дээрх их дээд сургуулийн багш нартай санал солилцоход:

- 1990-ээд он гэхэд эрдэс баялгийн чиглэлээр сурч буй эмэгтэй оюутнуудын хувь 15 хүрэхгүй байсан бол 2000-д оны эхэн үеэс эхлэн аажмаар тасралтгүй нэмэгдсээр одоо зарим чиглэлийн ангиудад 60 хүртэл хувь нь охид байна.
- Охид голцуу уул уурхайн менежмент, маркшедер, ашиглалт, баяжуулалт зэрэг мэргэжлийг сонгодог. Эдгээр охидын олон нь хөдөө орон нутгаас ирсэн оюутнууд. Эмэгтэй оюутнууд сурлага харьцангуй сайн байдаг.



#### ЦААШДЫН АЖИЛ

- Хөдөө орон нутагт бүртгэлтэй уул уурхайн компаниудыг судалгаанд хамруулах
- Бичил уурхай, гар аргаар ашигт малтмал олборлогсодын хүйсийн харьцааны асуудлыг судлаж, тайланд оруулах
- Төрийн өмчийн компаниудыг тусад нь авч үзэх
- Эмэгтэйчүүдийн удирдсан уул уурхайн компаниуд зээл авах боломж ямар байгаа талаар банкуудаас судлах

## СУДЛААЧДЫН БАГ



Н.Түмэнбаяр, ахлах судлаач

- МУУЭ ТББ-ын удирдах зөвлөлийн дарга
- “TemugeLaw” хуулийн компани ([www.temugelaw.com](http://www.temugelaw.com))-ийн захирал
- УИХ-ын ТГ-т зөвлөх, IFC, EBRD, Вашингтон дахь МУ-ын ЭСЯ-нд зөвлөх байсан
- МГУ-н хуулийн ангийн LLM, АНУ-ын Корнеллийн их сургуулийн MPS цолтой



А.Намуун, туслах судлаач

- МУУЭ ТББ-ын Харилцаа, олон нийтийн хорооны дарга
- Уул уурхай, барилгын салбарт маркетингийн зөвлөх үйлчилгээний “Монголиа Маркет Партнерс” компани (<http://mmp.mn/>)-ийн гүйцэтгэх захирал
- Уул уурхай, барилгын ханган нийлүүлэлтийн салбарын хараат бус судлаач



Д.Отгончимэг, туслах судлаач

- Уул уурхай дахь эмэгтэйчүүдийн ТББ-ын удирдах зөвлөлийн гишүүн
- ОХУ-ын Санкт-Петербург хотын технологийн их сургуулийн химийн инженер
- ХБНГУ-ын Фрейбергийн Уулын академийн баялгийн менежментийн чиглэлээр магистр
- Монголын Алт (МАК) ХХК, Эрчим хүчний болон химийн төслүүдийн инженерингийн менежер
- НУБ-ын Хөгжлийн хөтөлбөрийн олборлох салбарын төслүүдийн үндэсний зөвлөх



Ж.Цэвээнжав, зөвлөх

- Шинжлэх ухааны доктор, ШУТИС-ын профессор, тэнхимын захирал ([www.guus.edu.mn](http://www.guus.edu.mn))
- Монголын Өрмийн инженерүүдийн холбооны гүйцэтгэх захирал ([www.mda.mn](http://www.mda.mn))
- Монголын Газрын тосны инженерүүдийн нийгэмлэгийн гүйцэтгэх захирал
- Монголын Газрын тос, хий, эрдэс баялгын комиссын гишүүн
- Олон улсын газрын тосны нийгэмлэг болон Австралийн өрмийн инженерүүдийн ассоциацийн гишүүн